



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

*Шинэчлэл бол*

*Сэтгэл гарган хийх ажил юм.*

Монгол Улсын  
Ерөнхий сайд

Норовын Алтанхуяг

ТӨР ХААЛГАА НЭЭВ, ИРГЭД ТӨРДӨӨ ҮНЭНИЙГ ХЭЛЖ,  
ТӨР ИРГЭДДЭЭ ҮЙЛЧИЛЖ БАЙНА



*Шинэчлэлийн Засгийн газар гарааны жилдээ хийж бүтээсэн 400 гаруй ажлаас иргэд, олон нийтэд түгээмэл ач холбогдолтой 125 ажлыг энэхүү эмхэтгэлд түгчвэрлэн оруулав.*



**Т**өрийн ордон түмэн олонд нээлттэй болов. 220 мянган хүн зочилж, Монгол төрийн түүхтэй танилцан, Есөн хөлт цагаан тугаа хүндэтгэв.



**Т**өрийн чих “11 11 төв”-ийг нээв. Монгол Улсын 60 мянга гаруй иргэний үг, санал хүрэх газартаа хүрэв. Иргэн нь өдөр бүр хэлж, төр нь ажил болгож байна.

**И**ргэддээ үйлчлэх үүрэгтэй төрийн байгууллагууд өглөөний 8 цагаас ажиллаж эхлэв. Илүү эртэч болж, иргэн нь ч, төр нь ч цаг хожиж байна.



**ТӨР ХААЛГАА НЭЭВ, ИРГЭД ТӨРДӨӨ ҮНЭНИЙГ ХЭЛЖ,  
ТӨР ИРГЭДДЭЭ ҮЙЛЧИЛЖ БАЙНА**

Гэмт хэрэг ихтэй гэр хорооллын иргэдэд цагдаа ойрхон болов. Дүүрэг бүрт цагдаагийн хэлтэс нэмж, 15 хэлтэстэй боллоо. “Иргэдэд үйлчлэх төв” 24 цагаар, 4000 хүн амд хэсгийн байцаагч, 15 мянган иргэн тутамд хэв журмын эргүүл хоёроос доошгүй ажиллаж байна. Цагдаа иргэндээ ойрхон, илүү шуурхай болов.



Улсын зардлаар гадаадад суралцагчдаас авах шалгалтыг ил тод болгов. Гадаадад сурахад арын хаалга, авлига хэрэггүй болов.

70 мянган аж ахуйн нэгж дугаарлаж зогсохгүй, цаг алдахгүй, цаас үйлдвэрлэхгүй, цахим хэлбэрээр санхүүгээ тайлагнадаг болов.




**ТӨР ХААЛГАА НЭЭВ, ИРГЭД ТӨРДӨӨ ҮНЭНИЙГ ХЭЛЖ,  
ТӨР ИРГЭДДЭЭ ҮЙЛЧИЛЖ БАЙНА**



Ажилд орох, банкнаас зээл авах, гадаадын виз мэдүүлэхэд цагдаагийн тодорхойлолт шаарддаг байсныг цуцлав. Ам цаас, алтан цаг хэмнэв.

Бүтээн байгуулалтын чөдрийг тайлав. Барилгын ажил эхлэхэд 200 гаруй хоног хэрэгтэй байсан бол 30-35 хоногт амждаг боллоо.



Хаалга нь цоожтой дотоод ажлын өдрийг алга болгов.

Тендер бүрэн цахимжив. Цаг хугацаа, орон зайны саадгүй цахим хэлбэр зардал мөнгө хэмнэж, эрх мэдэлтэн, иргэн хоёрын ялгаа арилав.



## ТӨР ХААЛГАА НЭЭВ, ИРГЭД ТӨРДӨӨ ҮНЭНИЙГ ХЭЛЖ, ТӨР ИРГЭДДЭЭ ҮЙЛЧИЛЖ БАЙНА



мөнгө угаах зэрэг зохион байгуулалттай үйлддэг гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөх алба удахгүй ажиллаж эхэлнэ.

**И**ргэний бүртгэлийн төрсний бүртгэлийн, иргэний үнэмлэхний, гэрлэлт бүртгэлт, гэрлэлт цуцлалтын бүртгэл, гэрлэлт бүртгэлгүй тухай лавлагаа, оршин суугаа хаягийн тодорхойлолт, ААН-ын орлогын албан татварын лавлагааг шууд хэвлэн авах боломжтой Төрийн Үйлчилгээний Цахим /ТҮЦ/ машин Нийслэлд 17 ажиллаж байна. Энэ намар аймаг бүрт 5-аас доошгүй ТҮЦ машин ажиллана.



**Э**кспорт, импорт хийхэд шаардагддаг хүнд суртал болсон тус бүр 11 бичиг баримтыг цөөлж, зөвхөн 2-4 тодорхойлолтыг хувийн хэвшлийнхэн, хувь хүмүүсээс гаргуулдаг боллоо.

## ТӨР ХААЛГАА НЭЭВ, ИРГЭД ТӨРДӨӨ ҮНЭНИЙГ ХЭЛЖ, ТӨР ИРГЭДДЭЭ ҮЙЛЧИЛЖ БАЙНА



**З**охион байгуулалттай, далд үйлдэгддэг хар тамхи, хүн худалдаалах, зэвсгийн наймаа, мал хулгайлах, байгаль экологийн гэмт хэрэг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад оны эхний 8 сарын байдлаар 3-80 хувиар буурав. Эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашигласан гэмт хэрэг дахин гараагүй байна. Улсын мөрдөн байцаах газар олон жилийн турш ах дүү, амраг саднаараа нийлэн татвар төлөгчдийн хөлс хүч шингэсэн мөнгөөр халаас, хэтэвчээ түнтийлгэдэг байсан нууц ноёдын булхай, луйврыг түрүүчээс нь илрүүлж эхлээд байна.



**И**потекийн 8 хувийн хүүтэй зээл олгож эхэлсэнтэй холбогдуулан, шүүхийн шийдвэрийн өр төлбөргүйн лавлагааг шууд цахимаар банкуудад шилжүүлж байна.

**Ү**ндэсний стандартын шинжлэх ухаан, техникийн түвшингийн улсын үзлэгийг 20 аймаг, 14 яам, 3 агентлагт зохион байгуулав. Мөрдөгдөж буй нийт 5929 стандартаас 2724-ыг хэвээр мөрдөх, 2407-г нь дахин хянах, 478-ыг нь хүчингүй болгох, 1251-ыг шинээр боловсруулахаар болов.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 сарын 28 өдөр Төрийн ордон, Улаанбаатар хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧӨЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

60.3. Мэдүүлэгч гаалийн мэдүүлэгт өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад өгнө.

60.3.1. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэл;  
60.3.2. тээврийн бичиг баримт;  
60.3.3. тарифын бус хязгаарлалтад хамаарах бараанд шаардагдах зөвшөөрөл, лиценз;



**Х**өдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн, 192 мянган төгрөг болголоо.



**А**жлын байр хамгийн ихээр бий болгогч жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт хийсний үр өгөөж иргэддээ хүрэв. Эхний 8 сард 35000 гаруй хүн хийдэг ажилтай, авдаг цалинтай боллоо.



**“Сум хөгжүүлэх сан”-гийн** эх үүсвэрээс өнгөрсөн онуудад 21 аймгийн 330 суманд нийтдээ 72 тэрбум төгрөгийн санхүүлжилт олгосны дунд сүүлийн нэг жилийн хугацаанд 7389 ажлын байр шинээр бий болжээ.

**Э**дийн засгийн тэргүүлэгч салбар уул уурхай, барилга, зам тээвэр, аж үйлдвэрт эрэлт хэрэгцээ ихтэй мэргэжлээр 7000 ажилчин бэлтгэн гаргав. Долоон мянган шинэ монгол ажилчин бүтээн байгуулалтад хүч нэмэв.



**Х**аана, хэр цалинтай, ямар ажил байгааг хаанаас ч мэдэх боломжтой. Е-бирж нийслэлийн 9 дүүрэг, 134 хороонд, 21 аймгийн интернэтэд холбогдсон 142 суманд ажиллаж эхлэв. Ажил хайгч, ажил олгогчийг хооронд нь шууд уулзуулсан, хольг ойртуулсан шулуун шугам татав.





Нийгмийн хамгааллын үйлчилгээний төвүүд хилийн чанадад ажиллаж эхлэв. Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэтгэврийн даатгалд хамруулах, гадаад улс оронд төлсөн шимтгэлийг нь буцаан олгуулах зэрэг эн тэргүүний хэрэгцээ шаардлагатай үйлчилгээ үзүүлж байна.



“Сумын залуус”, “Ажлын гараа” төсөлд 1700 оюутан оролцлоо. Малын өвөлжөөнөөс барилга, замын бүтээн байгуулалт хүртэлх талбарт оюутнууд хүч нэмж, ажилтай бүтээлтэй, цалинтай орлоготой амрав.

Монгол залуус олуулаа эх орон, төрсөн гэртээ эргэн ирж байна. “Залуучуудын хөгжлийн хөтөлбөр 2013-2017” цогц хөтөлбөр хүний нутагт хөлсний ажилчин биш эх орондоо эзний ёсоор ажиллаж амьдарч, илүү тав тухтай аж төрөх нөхцөл бүрдүүлэв. Солонгост ажилладаг монголчуудын тоо нэг жилийн дотор 18 хувиар буурав.



Сурагчдын 70 хувь нь “Монголд үйлдвэрлэв” шошготой, илүү чанар, өнгө үзэмжтэй шинэ дүрэмт хувцас өмсөж эхэллээ. Монгол мэргэжилтний ур хийц, монгол ажилчны сэтгэл зүтгэлээр 350 шахам мянган дүрэмт хувцсыг дотоодын 100 гаруй үйлдвэр хүч боломжоо хамтатган бүтээж, 1300 гаруй ажлын байр баталгаажлаа. Засгийн газраас зээлээр олгосон 23 тэрбум төгрөгийг дүрэмт хувцас борлуулсан орлогоос буцаан төвлөрүүлнэ.

Ногоочид сэтгэл, зүтгэлээ шингээн ургуулсан ногоогоо Улаанбаатарын 26 цэгт байгуулсан тусгай төвд түрээсгүй борлуулж, хөлс хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэж байна. Эх орны хөрсөнд ургасан эрүүл чанартай ногооны үнэ хямдарч, хотын иргэд ч мөнгөө хэмнэв.



Нийт 6700 гаруй хоригдлын 50 гаруй хувь нь ажлын байртай болов. Төлбөр барагдуулах ёстой 176 ялан цалин орлогоосоо өр төлбөрөө барагдуулж байна.

Хийсэн ажилгүй өдөр хоног өнгөрөөдөг байсан хоригдлуудад мэргэжил олгож, ажлын байраар хангаж эхлэв. Оны эхний хагасын байдлаар 435 ялан цахилгаанчин, засал чимэглэлчин, сантехникч, гагнуурчин, бетон арматурчины мэргэжлийн эзэмшиж, үнэмлэхээ гардав.

ЭЗНЭЭ ОЛСОН, ИРГЭНДЭЭ ХАЯГЛАСАН ХАЛАМЖ,  
ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Хавтгайрсан биш илүү хэрэгтэй эзнээ олсон, иргэндээ хаяглаж хүрсэн нийгмийн хамгаалалд шилжиж, тэтгэмжийн хэмжээг нэмлээ.



Хоёр болон гурван ихэр хүүхдэд олгодог байсан 120, 180 мянган төгрөгийг 1-3 сая төгрөгт хүргэж нэмлээ.

Ажилласан жил дутуу, олон он дамжин тасарснаас тэтгэврээ авч чадахгүй байсан, бага тогтоолгосон 465 мянган иргэн тэтгэмжээ нөхөж тооцуулав. Бас тэтгэврийн хэмжээ нь өсөв.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**АЖИЛЛАСАН ЖИЛ, ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТООЦОХ ТУХАЙ**

МОНГОЛ УЛС

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ДЭВТЭР

1995-2000

1990-1995

Энэ хуульд тусгагдсан төлөвлөгөөг буюу төсөл эхэлжээгүй байсан бий тухайн үеийн төсөл үзлийн хэлсний доор хэмжээгээс 15% хоцрогч төлүүсэн нийгмийн даатгалын шимтгэлээ төлсөнд тооцүүлна.

Энэ хооронд ажилласан жил нь тасарсан хугацааг ажилласнаар нөхөн тооцно.

ЭЗНЭЭ ОЛСОН, ИРГЭНДЭЭ ХАЯГЛАСАН ХАЛАМЖ,  
ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн унааны зардлын 90 мянган төгрөгийг 200 мянга болгож, хараагүй иргэний сар бүрийн тэтгэмж 10 мянган төгрөгийг хоёр дахин нэмлээ.



Хүн амын 35 хувийг эзэлдэг 930 мянган бяцхан иргэддээ “Хүүхдийн мөнгө”-ийг дахин олгож эхэллээ. “Хүүхдийн мөнгө” авахдаа дараалалд зогсох шаардлагагүй боллоо.



Хувь хүний хөгжлийг дэмжих “Амьдрах ухаан-амжилтын хөтөч” төсөл хэрэгжиж, 8000 орчим иргэн сургалтад хамрагдлаа.

## ЭЗНЭЭ ОЛСОН, ИРГЭНДЭЭ ХАЯГЛАСАН ХАЛАМЖ, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Улсын нэгдүгээр төв эмнэлэгт Элэг, үүдэл эс шилжүүлэн суулгах лаборатори байгуулав. Эрхтэн шилжүүлэн суулгахад шаардлагатай шинжилгээг эх орондоо хийлгэж эхлэв.



**14** хүртэлх насны гурав ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд жилд нэг удаа олгодог 60 мянган төгрөгийг 120 мянга болгов.

Тамхины хяналтын тухай хууль хэрэгжүүлэн, нийтийн тээврийн хэрэгсэл, баар, ресторан, олон нийтийн газарт тамхи татахыг бүрэн хориглов. Эрүүл зан үйлийг дэмжсэн ажил бодитой хэрэгжиж, иргэдийн дэмжлэг талархлыг хүлээв.

**ТАМХИ ТАТАХЫГ ХОРИГЛООН ГАЗРУУД**

- Зочны тээврийн буудал
- Зочид буудал, нийтийн тамхины тамхи татаж болохгүй газар
- Хуулийн нэгдэл
- Зочны тээврийн галт тэрэг
- Олон нийтийн үзэср
- Ийнхүүтэй газар
- Цэцэрлэг
- Энгийн сургууль
- Энгийн сургуулийн өмнө тээврийн газартай ойролцоо
- Нийтийн хоол
- Хувийн
- Ваучер цэнгээний газар
- Аж ахуйн нэгж
- Материалын болон барилгын дотоод орчин
- Бус тусгай нийтийн тээврийн хэрэгсэл
- Шашны тусгай газар
- Шатаа, тослох, тосгож, дуусгах бодис
- Нийтийн газартай ойролцоо
- Нийтийн газартай ойролцоо суугаа, байрны өмнө
- Орц, цагаан хайр, хувийн тогтоомын талбай
- Цэцэрлэгт хоригоо

**ТАМХИ ХУДАГДАЛЫГ ХОРИГЛООН ГАЗРУУД**

- Тамхи борлуулах албаа цэрт
- Тамхины үйлдвэр
- Тамхины өргөтгөлийн шилжүүлэгч
- Тамхины үйлдвэр
- 21 нас хүртэлх тамхи хуудалыг
- Тамхины үйлдвэр
- Ерөнхий боловсролын сургуулийн
- Иргэдийн олон нийтийн
- Байрны дотоод орчин
- Интернетээр
- Ваучер цэнгээний газар

**ХУУЛЬ ЗӨРЧӨВӨЛ**

Иргэн: 60,000 ТӨГРОНО

АЛДАН ТУШАЛТАЙ: НЭГ САНХИЙ ХАДАГЧИЙН ХАМГААГАХ ДУУС ЭМБЕЛЭГ 10-25 ДАХИЙН НӨМӨГ ДУУСГАЙН ТӨМӨХ ХАМГААГАХИЙГ ТӨГРӨГӨӨР ТӨГРОНО, ХУУЛИЙН ЗТГЭЛЭГ 10-25 ДАХИЙН ХАДАГЧИЙН ХАМГААГАХ ДУУС ЭМБЕЛЭГ 10-25 ДАХИЙН НӨМӨГ ДУУСГАЙН ТӨМӨХ ХАМГААГАХИЙГ ТӨГРӨГӨӨР ТӨГРОНО, ТАМХИ БОЛОН ХУУЛЬ БУСААР БОЛОН ОРОЛГО БОЛОН СУРАЛЧИЛАГАНЫ МАТЕРИАЛЫГ ХУДАА.

## ЭЗНЭЭ ОЛСОН, ИРГЭНДЭЭ ХАЯГЛАСАН ХАЛАМЖ, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Улсын гуравдугаар төв эмнэлэг зүрхний шигдээс, цус харвалттай өвчтөнд эрчимт эмчилгээ, нөхөн сэргээх цогц тусламжийг цаг тухайд нь үзүүлдэг болов.

Амьжиргааны баталгаат түвшнээс доогуур орлоготой, эмзэг бүлгийн иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, хоёрдугаар шатлалын эмнэлэгт оношилгоо эмчилгээ хийлгэлээ. Эмнэлэгт хэвтэх шаардлагатай иргэдийг хэвтүүлж эмчлүүлэв.



“Эрүүл амьдралын 5 алхам”-ыг боловсруулж нарны гүйлт, нарны алхалт, нарны дасгалыг улс орон даяар эхлүүлж иргэдийн амьдралд хэвшүүлэх ажил эхэллээ. Халдварт бус өвчнийг бууруулах хямд төсөр энэ алхмуудыг иргэн бүр өдөр тутмын амьдралын хэрэгцээ болгохыг зорьж байна.





**Х**от, хөдөөгийн ялгааг багасгах, аймгийн төв бүрийг орчин үеийн хот болгох зорилт тавьсан Шинэчлэлийн Засгийн газар асуудлаа шийдэж, ажлаа хийж байна. Нэг жилийн дотор Ерөнхий сайд Н.Алтанхуяг 17 аймагт ажиллажээ.

**С**ум, дүүрэг бүрт “Орон нутгийн хөгжлийн сан” ажиллаж байна. Иргэд өөрсдөө төсвийн хөрөнгөөр хаана, хэзээ, хэрхэн, юу хийхээ илүү олуулаа хэлэлцэн шийдэж байна. Иргэд өөрсдөө мэдэх мөнгө сум бүрт 300 саяас доошгүйг, улсын хэмжээгээр энэ онд нийт 250 шахам тэрбум төгрөг олголоо.



**Ш**инэчлэлийн Засгийн газрын “11 11 төв”-ийн жишиг 21 аймагт тэлж, орон нутгийн удирдлага иргэдээ үргэлж сонсох утастай, иргэдтэйгээ хэлэлцэн ярилцах танхимтай болов.



**11** аймгийн нэгдсэн эмнэлэг дэх иж бүрэн оношилгооны төв, хот руу хол явах хэрэггүй болгов. 2015 он гэхэд бүх аймагт иж бүрэн оношилгооны төв үүдээ нээнэ.



**М**онгол хүн төрж өссөн нутаг ус, аймаг сумандаа ая тухтай амьдрах бодит жишиг, баримтлах загвар болгон Баянхонгор аймгийн Баянлиг, Бууцагаан, Дорноговийн Замын-Үүдэд “Сумын төвийн шинэчлэл” төсөл хэрэгжиж эхэллээ. Сумын шинэ төвүүд сургууль, цэцэрлэг, дотуур байр, уурын зуух, эмнэлэг, соёл, спортын төв, нутгийн хөгжлийн ордонтой болж байна.



**М**алчид малынхаа ашиг тус, өгөөж буяныг илүү хүртэхэд тусалж үйлчлэх “Хөдөө аж ахуйн бирж” нээгдэж, хэдхэн сард 360 тэрбум гаруй төгрөгийн борлуулалт хийлээ. Малчид хотноосоо 358 тэрбум төгрөгийн ноолуур, 3.3 тэрбум төгрөгийн тэмээний ноос, 471 сая төгрөгийн хонины ноос борлуулсан байна.



Дотоодын нийт бүтээгдэхүүний 12 хувийг гардан бүтээдэг малчдыг “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч” хэмээн төр анх удаа батламжлав. Малчид нийгмийн хөгжилд илүү хариуцлагатай оролцогчид болж байна. Батламжтай малчин ноос, мах, сүүний урамшуулал авч, хөдөлмөрөө хоршиж ажиллах, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, бизнесээ хөгжүүлэх өргөн боломжтой болов.

Өвлийн бэлтгэлийг зунаас хангаж, нөөцийн өвснийхөө 70 хувийг аймгууд өөрсдөө бэлтгэж байна.



Хөдөөгийн иргэд хамтран хоршиж, нутаг ус, ан амьтнаа хамгаалдаг боллоо.



Монгол нутгийн хэвлийгээс олборлосон газрын тосоо урд хөршид боловсруулж “Монгол-93” шатахуун гаргалаа.



“Эрдэнэт үйлдвэр”-ийн нөөцийг дахин 25-30 жилээр нэмлээ. Монголчууд эрдэнэс баялгийн үүц болсон энэ ордын ашгийг ахиад хагас зуун жил хүртэнэ.

Төмөр замын дэр мод ашиглахыг зогсоов. Жилдээ 40 мянган шоо метр мод огтлогдохгүй ойдоо үлдэж байна. Цахилгааны шонгийн тулгуурт мод ашиглахыг 2014 оноос зогсоох шийдвэр гаргалаа. Гадаадаас худалдан авах модыг гааль, НӨАТ-аас чөлөөлөв.






**Б**огдхан уул, Горхи-Тэрэлж, Хөвсгөлийн байгалийн цогцолборт газар ашиглах зөвшөөрөл олгохыг бүрэн зогсоож, унаган байгалийн баялаг өвөө төр хамгаалалтаа бүрэн авлаа.



**Б**агануурын уурхайн орд газарт хувийн компаниудад хууль бусаар олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов. Нүүрс олборлолт нь нэмэгдэв.



**М**онгол банкттай хамтран багц хөтөлбөр хэрэгжүүлж, цалин орлогоос хумслэгч инфляцид илүү нөлөөлдөг гол нэрийн бараа, бүтээгдэхүүний жижиглэн худалдааны үнийг дунд хугацаанд хазаарлаж чадлаа.



**Ү**р дагавартай нь бус үндсэн шалтгааныг нь арилгахаар ажиллав. Хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх үндэс шалтгааныг нь арилгах дэд хөтөлбөрүүдэд 248 тэрбум төгрөг олгов. Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд гурилын үнэ тогтвортой байж, нөөцийн махаар тасралтгүй хангаж чадлаа.

**И**ргэдэд очих нүүрсний үнийг 2,5 дахин бууруулж, 200 мянган төгрөг байсан нэг тонн нүүрсийг 80 мянган төгрөг болтол хямдрууллаа.



## ЦАЛИН, ОРЛОГЫГ ҮНЭГҮЙДҮҮЛДЭГ ҮНИЙН ӨСӨЛТИЙГ ХАЗААРЛАВ



Өргөн хэрэглээний барааг Замын-Үүдээс Улаанбаатар хүртэл 24 цагийн дотор тээвэрлэдэг боллоо.

Барилгын өртөг бууруулах зорилгоор цемент, арматур нөөцлөх, нийлүүлэх 56 аж ахуйн нэгжид 129,4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо. Цементийн үнэ тонн нь 200 гаруй мянган төгрөг байсныг 135-145 мянган төгрөг болгон хямдруулаа.



Шатахууны үнэ 50 төгрөгөөр хямдрав. Машинтай иргэн жилдээ 200 гаруй мянган төгрөг хэмнэх боллоо.

## МОНГОЛ БАХАРХАЛ МОНГОЛД ТҮГЭВ



Хямдхан олдоогүй ялалтын эзэд, алтан соёмбот далбаагаа тив, дэлхий, олимпод мандуулсан үе үеийн тамирчдад сар бүр 500 мянгаас 4 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгож эхлэв. Амжилтыг нь насан туршид нь төр засаг үнэлсэн урамшуулал эх орноо дэлхийд таниулах итгэл найдварын гал нэмэв.



Шонхор наймаа биш бахархал болов. Эрч хүч, зориг зүрх, эрх чөлөө, эх нутгаа хайрлах үзлийн бэлгэдэл идлэг шонхрыг Үндэсний бахархалт шувуугаар зарлав. Экспортод арилжааны зориулалтаар гаргахыг хориглов.



бүтээж үйлдвэрлэж чаддагаа өөрсдөө нотлов.

**Э**рээн хотруу гардаг мөнгө эх орондоо үлдэв. Монгол Улсын Ерөнхий сайд эх орныхоо үйлдвэрийн бүтээгдэхүүнээс бэлэг сонгохыг уриалав, биечлэн сурталчлав. “Цагаан сар-Монголд үйлдвэрлэв 2013” үзэсгэлэн худалдааны борлуулалтын орлого 2,7 тэрбум төгрөгт хүрчээ. Монголчууд бие биенээ дэмжиж,



**М**онгол Улс 2016 онд үндэсний хиймэл дагуул ашиглаж эхэлнэ. “Үндэсний хиймэл дагуул” хөтөлбөр баталж, харилцаа холбоо, тандан судалгааны хоёр хиймэл дагуул хөөргөхөөр бэлтгэж байна.

**2016** оны наадам Төв цэнгэлдэхэд биш Хүй долоон худагт болно. Монгол наадмын төв болгох эхлэл суурийг энэ жилийн наадмаар тавив. Хүй долоон худаг засмал замтай, тоглолт, үйлчилгээний талбайтай, 3000 үзэгчдийн суудалтай, 7000 машины зогсоолтой болов.



**Ш**инэчлэлийн Засгийн газар гарааны жилдээ 42 хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж хэлэлцүүлээ.



**Э**х орондоо барилгын материал үйлдвэрлэж, дөрвөн улирлын туршид тасралтгүй бүтээн байгуулах эхний үйлдвэрүүд үүдээ нээх эхлэл тавигдав.

Налайхад барилгын материалын үйлдвэрлэл технологийн парк, Нийслэлд угсармал орон сууцны Байшин үйлдвэрлэх комбинат байгуулах гэрээ хийгдэж, эхний ээлжийн санхүүжилт хийгдлээ.



Чингис хааны үр сад дэлхийн тавцанд эргэн ирж байна. Монгол Улс зээл тусламж хүртэгч биш хөрөнгө оруулалт татдаг орон болсноо нотлон, олон улсын зах зээлд 1,5 тэрбум долларын “Чингис” бонд амжилттай арилжаалав. Бүтээн байгуулалтад зориулж байгаа бонд дотоодын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлж, эдийн засгийн өсөлтийг хангасан давхар үр өгөөж өгөв.



Орон сууцны нийлүүлэлтийг дэмжиж 404 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг Монгол банк арилжааны банкуудаар дамжуулан хот хөдөөгийн 77 компанид олгов.



“Төрийн орон сууцны корпораци” /ТОСК/-ийг байгуулаа. ТОСК түрээсийн байр олноор барьж, иргэдэд хямд үнэ, боломжийн нөхцөл санал болгох ажлыг хариуцан ажиллана.



“Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд шинэ суурьшилын бүс бий болгох ажил эхэлж, гэр хороололд орчин үеийн хорооллын дэд бүтэц тавьж эхэлж байна. Гэр хорооллын дахин төлөвлөлтөөр 184 мянган өрх буюу 700 мянган иргэний амьдрах орчныг үндсээр нь өөрчилж, Улаанбаатарын агаар, хөрсний бохирдлыг арилгана.




мянган иргэний зээлийн хүү хоёр дахин багасав.

**Б**арилгын материалын үйлдвэрүүдийн эргэлтийн хөрөнгө үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд 64 аж ахуйн нэгжид 146,7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо.



**З**амын-Үүд боомтыг өргөтгөн шинэчилж, хоёр терминалтай болгон, ачаа эргэлт 2-3 дахин нэмэгдэв. Бүтээн байгуулалтын бараа, түүхий эдийн хил гааль дахь түгжрэл саад арилав.



сууц, 2014 оны 5-р сард үлдсэн 1075 айлын орон сууц ашиглалтанд орох юм.

**Ү**ндэсний компаниуд нэгдэн нэг жилийн дотор орон сууцны бүтэн хороолол барьж байна. “Буянт-Ухаа-1” хороололд 1575 айлын 25 барилга, 128 хүүхдийн цэцэрлэг, үйлчилгээний төв баригдана. 2013 онд эхний 500 айлын орон



**Э**нэ жилдээ багтаан 1700 км орчим замыг бүрэн дуусгаж хүлээж авна. Өнгөрсөн дөрвөн жилийн нийлбэр замаас нэг жилийн дотор 400 км илүү урт зам ашиглалтад оруулж буй нь түүхэн дээд амжилт.

**Т**өв аймгийн Хөшигийн хөндийд олон улсын нисэх онгоцны буудал барьж эхлэв. Манай улсын газар зүйн байршлын онцгой давуу талыг бүрэн дүүрэн ашиглаж, Монголын хөх тэнгэрээр дамжин өнгөрөх баруун Европ, Америк Азииг холбосон агаарын зам бий болно. Жилд 3 сая зорчигчдод үйлчилж, шинэ дагуул хот үүсгэн хөгжүүлэх орчин үеийн олон улсын шинэ нисэх буудлыг 2016 оны 12 дугаар сард нээнэ.





**О**нгоц түрээсэлж, илүү зардал төлж байсан Монгол Улс анх удаа “Боинг 767-300 ER” агаарын тээврийн шинэ хөлөгтэй боллоо.

Алс баруун, зүүн хязгаар нутаг Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Ховдын Булган, Завханы Тосонцэнгэл чиглэлийн нислэгийг сэргээлээ. 2013 онд Эрээн, Шанхай, Бангкок чиглэлд олон улсын шинэ нислэг эхлэв.

**Ж**илд 50 сая тн ачаа тээвэрлэн, экспортын бүтээгдэхүүнээ зах зээлд нь хүргэх төмөр замын бүтээн байгуулалт эхлэн өрнөв. Ухаахудагаас Гашуунсухайт хүртэлх 267 км төмөр замын шугамын доод бүтцийн далан, ул шороо, хоолойн барилгын ажил 40 хувьтай байна.



**М**онгол инженерүүд Монголдоо угсарч, замд нь гаргасан “Хоёр загал” нэртэй 3 зүтгүүр урсгал зардлыг 40 хувь хэмнэж байна.



**Ө**дөрт 100 мянга, жилд 36 сая тонн хүдэр боловсруулж, сая тонн зэсийн баяжмал экспортлох хүчин чадалтай Оюутолгойн баяжуулах үйлдвэрийн хүрд эргэж эхлэв. ДНБ-д эзлэх уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээ 20 хувиар өсч, анхны баяжмалаа эскпортолж эхлэв.

**“Г**удамж” төслөөр энэ онд дөрвөн замын уулзвар 33-ыг ашиглалтад оруулахаас өнөөдрийн байдлаар 20 орчим нь нээгдэв. Гацаж түгжрүүлдэг, удааж зогсоодог хуучин уулзварууд гэрэл зурагт үлдэв.



**Н**ийслэлтэй хатуу хучилттай замаар энэ онд 6 аймгийг холбохоос Баянхонгор, Сайншандын зам ашиглалтад оров. 11 сард Сайншанд Замын-Үүдийн зам ашиглалтад орсноор Монгол, Орос, Хятадыг холбосон босоо тэнхлэгийн авто зам бүрэн болно.





Он он дамжсан ч ярианаас хэтрээгүй, хэн барих нь тодорхойгүй байсан 5-р цахилгаан станцын барилгын ажлыг 2014 оны 7 дугаар сард эхлүүлэхээр боллоо. Концессийн гэрээний дагуу гурван жил хагасын дотор ашиглалтад хүлээлгэн өгнө.

Жилд 2 сая тн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг 2015 онд ашиглалтад оруулахаар эцэслэн шийдвэрлэв. Шинэ үйлдвэр ойрын жилүүдэд улс орныг түлш шатахууны хараат байдлаас гаргана.




Нийслэлийн зүүн хэсгийн 50 гаруй мянган айл өрх өнтэй өвөлжих найдвартай эх үүсвэр болох Амгалан дулааны станцын барилгын ажил эхэллээ. Ирэх оны 8 дугаар сард бүрэн хүчин чадлаараа ашиглалтад орно.

Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын буцалтгүй тусламжаар олон улсын ISO 17025 стандарттай, орчин үеийн өндөр нарийвчлалтай багаж, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, хүнс, эмийн аюулгүйн үзүүлэлтийг шинжлэх нэгдсэн төв лаборатори хүлээн авав.



Дөрөвдүгээр цахилгаан станцын хүчин чадлыг 100 МВт эрчим хүч, 180 Гкал дулаанаар нэмэхээр ажиллаж байна. Уралын турбины үйлдвэрийн Т-120/130 маркын турбогенератор суурилуулж, 2014 оны 3-р улиралд ашиглалтад оруулна.



**Т**яньжин хотын Дуньзян боомтод Монгол Улсын Засгийн газар 10 га газартай болов. Олон улсын далайн тээврийн боомтод өөрийн газартай болсноор ачаа эргэлт нэмэгдэж, Монголын брэнд бүтээгдэхүүний экспортод татварын хөнгөлөлт эдлэх боломж бодитой бүрдэв.



**Г**уравдугаар цахилгаан станцын хүчин чадлыг 50МВт-аар өргөтгөн, энэ ондоо багтаан ашиглалтад оруулна. Улаанбаатарын цахилгаан дулааны шинэ эх үүсвэр ашиглалтад орох хүртэл хэрэглээний өсөлтийг найдвартай хангах болов.

**Н**ийслэлийн 12 мянган өрх хөдөөгийн 105 сумын хэрэглэгчдийн цахилгааны хангамжийг сайжруулав.



450 Мвт-ын эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай Таван толгойн цахилгаан станц 2017 онд ашиглалтад орно. Шинэ станцын бүтээн байгуулалтад бондын хөрөнгөөс 50 сая ам.доллар зарцуулах бөгөөд Тавантолгойн уурхайг түшиглэсэн станц Монгол Улсын өсөн нэмэгдсээр байгаа эрчим хүч, гэрэл цахилгааны хэрэглээг хангана.

**И**нженерийн дэд бүтцийг нэгдсэн бодлогоор барьж байгуулах, технологийн шинэчлэлт хийх зорилтын хүрээнд нийт 416 тэрбум төгрөгийн ажил хийнэ. Үүнээс 200 тэрбум төгрөгийн ажил энэ онд хийгдэж байна.



**Т**өв аймгийн Сэргэлэн сумын Салхит ууланд 50 МВт-ын том чадлын салхин цахилгаан станц ашиглалтад оруулав. Салхин цахилгаан станц 50 мянган айл өрхийг хангах 30 гаруй МВт-ын эрчим хүч нийлүүлж байна. Жилд 150000 тонн нүүрс хэмнэж, хүлэмжийн хийн ялгарлыг 180000 тонноор багасгав.



Монгол Улс дэлхийн ардчилсан ертөнцийг манлайлж, түүхэндээ анх удаа Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг хоёр жил даргалав. Ардчилсан ертөнцийн хараа Монголруу чиглэж, ардчилсан орнуудын 7 дугаар бага хурлыг амжилттай зохион байгуулав.



Шинэчлэлийн Засгийн газраас баримталж буй бодлого, үйл ажиллагааг таниулан мэдээлэх “Ерөнхий сайд ба 10 асуулт, хариулт” уулзалтад Монгол Улсад суугаа Элчин сайд нар, дипломат төлөөлөгчид, олон улсын байгууллагын удирдлага оролцов. Гадаадын хөрөнгө оруулагчдыг урьж хамтран ажиллах их бүтээн байгуулалтын том төслүүдээ дэлгэрэнгүй танилцуулав.




ОХУ, Европын холбооны улсуудыг хамруулахаар ажиллаж байна.

Монголчууд Беларусь, Герман, Бруней, Колумб, Перу зэрэг 15 улсад хөнгөлөлтэй визээр зорчиж эхлэв. Монгол Улс иргэдээ олон оронд визгүй зорчих, хөнгөлөлт эдлэх хэлэлцээ явуулан, БНСУ, АНУ, Япон,



Экспортыг нэмж, эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэх бодитой санаачилга гаргах нь Монголын дипломат төлөөлөгчдийн ажлын үндсэн гол шалгуур болов.



Монгол Улсын гадаад нэр хүнд өсөхийн хэрээр төр засгийн өндөр хэмжээний айлчлалын давтамж нэмэгдэн нэг жилийн дотор дөрвөн орны Засгийн газрын тэргүүн Монголд айлчлан ирэв.



**М**онгол цэрэг дэлхийн энхийн манаанд үүрэг гүйцэтгэж байна. Олон улсын энхийг дэмжих ажиллагаанд цэргийн 6 багийн 1285 цэрэг дайчин оролцов. НҮБ-ын гишүүн улс орнуудаас энхийн төлөөх үүрэг гүйцэтгэгч цэргийнхээ тоогоор манай улс эхний 25-д бичигдэв.

**Г**адаад дахь монголчуудад иргэний эрхээ эдэлж, эх орныхоо газраас өмчлөх, нийгмийн халамж, тэтгэмж авах боломж олгон, бүртгэж хэлэв. Хилийн чанд дахь иргэдийн сонгох эрхийг дээдлэн хүндэтгэн, ардчилсан төрөө байгуулахад оролцох эрх чөлөөгөө хоёр дахь удаагаа бататган эдлэв. Бүртгэгдсэн сонгогчдын 70 шахам хувь нь сонгуульд оролцов.



**Г**адаадад ажиллаж амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, холыг ойртуулж, хоёрыг уулзуулсан цахим хэлбэрээр мэдээ хүлээн авч шийдвэрлэдэг, 24 цаг завсаргүй ажилладаг 6226-2222 дугаарын тусгай шугам нээв. 39 оронд ажиллаж буй дипломат төлөөлөгчийн газрыг 45 болгон нэмж, үйлчилгээний байгууллага болгон шинэчилнэ.

*Монгол хүүхэд нэг бүрийн авьяасыг нээн хөгжүүлэх, монгол хүнээ хөгжлийн үнэт баялаг болгох “Авьяас”, “Ном”, “Багшийн хөгжил” хөтөлбөр хэрэгжиж байна.*



“**А**вьяас” хөтөлбөрийн үр дүнд 2012-2013 оны хичээлийн жилд 300 мянган хүүхэд дугуйлан, секцэд чадвараа нээн хөгжүүлсэн нь өмнөх жилийнхээс 200 мянгаар өсөв.

**Б**агш нар ч бас сурч байна. “Багшийн хөгжил” хөтөлбөрт 21 мянган багш мэргэжил дээшлүүлж, 12 мянган багш хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүйд суралцав.



“**Н**ом” хөтөлбөр хүрээгээ тэлсээр, цэцэрлэг, сургуулийн хүүхдүүд 250 мянган ном хүлээн авч уншиж байна.



**М**аргаашийн багшийн чанар өнөөдөр эхлэв. Багшийн сургуульд элсэгчдийн тал хувь нь 650-иас дээш оноонд хүрэв. Элсэгч 750-иас дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг нь төр хариуцах хөшүүрэг ажиллаж эхлэв. Ирээдүйн багш нар хөдөө дадлагажвал төр зардлыг нь дааж байна.



**Ц**эцэрлэгийн хүүхэд, бага ангийн сурагчдын үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 50 хувь нэмэв. Өсөх биед өдөр бүхэн хэрэгтэй амт чанартай хоол, илүү аминдэм шингэх боломж бүрдэв.



**Ү**ндэсний номын сан дэлхийн жишигт нийцсэн тоон үйлчилгээ нэвтрүүлж, оюуны үнэт дурсгалыг тоон хэлбэрт шилжүүлж эхлэв.

**Ш**инжлэх ухааны үнэт олдвор Т-Батаар аварга үлэг гүрвэлийн ясыг эх нутагт нь буцаан залав. Үлэг гүрвэлийн олдворын өлгий нутагт, палеонтологийн эрэл хайгуулын үр дүнг дотоод, гадаадын иргэдийн хүртээл болгох Үлэг гүрвэлийн төв музей байгуулахаар шийдвэрлэв.



**21** аймаг, 330 сумын нутаг дэвсгэрт явганаар, дугуйгаар, ердийн хөсгөөр аялан Монгол эх оронтой танилцах ойр, дунд, хол ангиллын 16,392 км аялын замын чиглэл тогтоов.

## БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ШИНЭЧЛЭЛ СОЁЛЫН ҮНЭТ БАЯЛАГ



Үндэсний үнэт өв соёлыг үе дамжуулан өртөөлөн залгагч, тээн хөгжүүлэгч туульчид, ардын авъяастны улсын уралдаан зохион байгуулав. Шалгарсан 11 хүнд “ТУУЛЬЧ” цол, зэрэг дэв олгон, авъяас билгээ өвлүүлэх шавь сургалтын төсөл хэрэгжүүлэх эрх олгов.



Хууль бусаар хил давуулах гэж байгаад хураагдсан 30 гаруй нэр төрлийн 300 орчим түүх, соёлын дурсгалт эд өлгийн зүйлсийг холбогдох музейд нь шилжүүллээ.



11 аймаг, 18 сумын соёлын төв, нийслэлийн хоёр дүүргийн соёлын ордонд орчин үеийн кино үзвэрийн танхим байгуулж, кино үзвэрийн сүлжээг шинэчлэн сэргээж эхлэв. Бүх аймагт байгуулах орчин үеийн шинэ кинотеатрын эхнийх нь энэ онд Замын-Үүдэд нээгдэнэ.

## БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ШИНЭЧЛЭЛ СОЁЛЫН ҮНЭТ БАЯЛАГ



Монгол эрдэмтэн судлаачдын нээлт, оюуны хөдөлмөрийг үнэлэн хөхиулж эхлэв. Шилдэг бүтээлийн оны дээд шагналд 100 сая төгрөг олгохоор шийдвэрлэв. Анхны шагналын эзэн нь академич, физикч Н.Намсрай байв.

Дэлхийн монгол иргэн ирээдүйгээ угтаж, олон улсын шилдэг 100 сургуулийн өндөр босго давсан бол төлбөрийг нь төр дааж байна.



ЮНЕСКО-д түүх соёлын хосгүй дурсгалт өв, 1819 онд бүтээгдсэн, 111 боть “Есөн Эрдэнийн Ганжуур” судрыг бүртгүүлэн баталгаажуулж, дэлхийд данслуулав.

*Иргэнээсээ хол, хаалттай, эрх мэдэлтэнд илүү ээлтэй байсан төрийн аппаратын хүнд суртлыг халах, шат бүхэнд нь шинэчилж өөрчлөх, албан тушаалтанд хариуцлага тооцох, олон нийт чөлөөтэй хянадаг байхад зориулсан ажлуудыг тогтмол орнцолж байна.*



**“Шинэчилж шийдье-222”:** Шийдэх асуудал, хийх ёстой бас хийх ёсгүй ажлаа тодорхойлон мэдэх, гарц, шийдэл хайн олох, шийдвэр гаргахаас өмнө иргэд, мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачдын үнэн үг, санал бодол, байр суурийг тусган хүлээн авах “Шинэчилж шийдье-222” хэлэлцүүлгийг сар бүрийн хоёр дахь долоо хоногийн хоёр дахь өдөр 14.00 цагаас зохион байгуулж хэвшив. Иргэний санал бодол бодитой зөв шийдвэр болдог энэхүү хэлэлцүүлгийг 11 удаа зохион байгуулжээ.



**“Аймгийн цахим хурал”:** Цаг алдаж, мөнгө үрэхгүйгээр мэдээллийн технологи ашиглан улсын нийслэлээс орон нутгийн удирдлагуудтай нүүр нүүрээ харан ярилцдаг “Аймгийн цахим хурал”-ыг сар бүрийн сүүлийн долоо хоногийн баасан гарагийн 13:30 цагт хийж тогтмолжив.



**“Хариуцлага, хяналт, хэрэгжилт”:** Яам, агентлагийн удирдлагуудтай нэг дор цахим шугамаар холбогдож, тулгамдсан асуудал бэрхшээлээ хэлэлцэж шийддэг, алдаа оноогоо шүүн дэнсэлдэг энэ хурлыг сар бүрийн эхний долоо хоногт зохион байгуулж байна.

**Шинэчлэлийн баатрууд:** “Монголдоо сайхан амьдарч болно” гэдгийг ахиц амжилт, сэтгэл зүтгэл, сэдэл санаачилгаараа батлан харуулж яваа эгэл жирийн атлаа ажилч хичээнгүй иргэдээ Ерөнхий сайд урин залж, бүтээлч санаа, бусдад тусалсан дэм, хөлс хөдөлмөрийнх нь үр шимийг өргөн олонд танилцуулж байна.





“Өглөөний шинэ санаа”: Хөгжилд нэмэр, дэвшилд түлхэц болох шинэ санаа шийдэл хүлээн авч, бодлого шийдвэртээ тусгахын тулд Шинэчлэлийн Засгийн газрын тэргүүн, сайд нар иргэдтэйгээ “Өглөөний шинэ санаа” цахим ярилцлагыг баасан гарагийн 08:20-10:00 цагт хийж байна. “Өглөөний шинэ санаа”-ны бүтээлч санаачилга, шинэ санаанаас үр дүнд хүрсэн бодитой ажил олон байна.



“Миний Монголын бахархал”: Ард түмний бахархал болсон амжилт, ялалтын эзэн иргэдээ Ерөнхий сайд өглөөний цайнд урьж байна. Амжилтын нууц хол биш ойроос, гадаадаас биш Монголоос нээгдсээр байна.



“Ерөнхий сайдын 30 минут”: Иргэддээ нээлттэй, ил тод, илүү тунгалаг байхын тулд Засгийн газрын тэргүүн сэтгүүлчидтэй тогтмол цагт уулзаж ярилцдаг боллоо. Улс оронд хамгийн бодитоор юу болж байна вэ? Засгийн газар ямар ажил, яагаад хийж байна вэ? Иргэд юунд анхаарах ёстой вэ? гэсэн энгийн боловч харилцан ойлголцох, хамтран ажиллах албан ёсны эх сурвалж, цаг үеэсээ хоцроогүй мэдээ байна. “Ерөнхий сайдын 30 минут” пүрэв гараг бүрийн 12.30-13.00 цагт болдог, өнөөдрийг хүртэл 15 удаагийн нээлттэй ярилцлага зохион байгуулав.



“Бүтээн байгуулалтын цаг”: Бид юу бүтээн босгож байна вэ, өнгөрсөн долоо хоногт ямар ажил хэрхэн өрнөв гэдгийг даваа гараг бүрийн 15:00 цагт Шинэчлэлийн Засгийн газрын гишүүд оролцсон “Бүтээн байгуулалтын цаг”-аар нээлттэй ярьж байна.





**Ш**инэчлэлийн Засгийн газар нэг жилийн хугацаанд 70 гаруй удаа хуралдаж 1230 орчим асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.